

АЙМГИЙН ИТХ-ЫН 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН , МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

**Аудитын код: ЗАА-2018/216/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 70463612, 99058189      Цахим хаяг: zavkhan@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 70462813, 99019467, 98323586      Цахим хаяг: Khash\_aud@yaoo.com

Ахлах аудитор:


Утас:      Цахим хаяг:

## Агуулга

---

|       |  |    |
|-------|--|----|
| 1     | Аудитын гэрчилгээ .....  | 2  |
| 2     | Аудитын тайлан .....   | 3  |
| 2.1   | Оршил .....  | 3  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....          | 3  |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....         | 4  |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....               | 4  |
| 2.5   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....                     | 6  |
| 2.6   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....                    | 7  |
| 2.7   | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....        | 7  |
| 2.7.1 | Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал .....                         | 8  |
| 2.7.2 | Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....                           | 8  |
| 2.7.3 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....        | 8  |
| 2.7.4 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... | 8  |
| 2.8   | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....   | 8  |
| 2.9   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                          | 8  |
| 2.10  | Шилэн дансны мэдээлэл .....  | 9  |
| 2.11  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....                 | 9  |
| 2.12  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....  | 10 |
| 3     | Менежментийн захидал .....   | 11 |
| 3.1   | Төсвийн зарцуулалт .....   | 12 |
| 3.2   | ГХУСАХ-ний ЗАРДАЛ .....  | 12 |
| 3.3   | Авлага .....   | 13 |
| 3.4   | Тээвэр шатахууны зардал .....  | 13 |

# 1 Аудитын гэрчилгээ



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ДАРГА Ц.БАЛХЯРВАА ТАНЛА

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
81000 Увсгайтай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2018.02.23 № 179  
Тангай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 –д заасны дагуу Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, швэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргах байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлшээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Аймгийн ИТХ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцоослыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санаг, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захиралч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.УЛАМБАЯР

STB-2017

152 420

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Аудитын тайланг Аймгийн Иргэдийн Хурлын Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Балхярваа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор *Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.*

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.*

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг *2017 оны 02 сарын 08* - наас *2017 оны 02 сарын 11* – ны хооронд хийж, аудитын тайланг *2017 оны 02 сарын 26* - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн

удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор Ч.Бямбасүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

“Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018 оны 02 сарын 07 – нд ирүүлсэн бөгөөд аудит хийлгэх хүсэлтээ төрийн аудитын байгууллагад 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 26–р албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг хуульд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангасан ил тод, нээлттэй, чадварлаг болгон төлөвшүүлж өхөгжлийн шинэ түвшинд хүргэж ирээд, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурласан орон нутгийнхаа эдийн засаг нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх тасаралтгүй үйл ажиллагаатай, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн ард иргэдийнхээ аж амьдралыг дээшлүүлж ая тухтай ажиллах амьдрах нөхцөл бүрдүүлэхэд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Тэргүүлэгчдээс гаргах бодлого, хэрэгжилтийг хангахад бүхий л талын нөхцөл бүрдүүлэхэд оршино.” эрхэм зорилгын дор -ийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.*

Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

- Тайлант хугацаанд Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь
- Нутгийн удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх.

- *Оролцоонд суурилсан НӨУБ-ыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.*
- *Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн бодлого үйлчилгээ үзүүлэх*
- *"Иргэдээ сонсож, иргэдийн оролцоог хангах", " Сүү өргөж хүндэтгэл үзүүлэх" уриалгыг хэрэгжүүлэх*
- *Ажлын албаны ажилтнуудын сахилга хариуцлагаг дээшлүүлэх, байгууллагын болон хувь хүмүүсийн эдийн засгийн хэмнэлтийг гаргах .....” гэх мэт зорилгыг дэвшүүлэн ажиллажээ.*

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.*

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:*

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

*Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.*

*Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.*

*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.*

*Тайлант онд хууль хяналт байгууллагуудаас шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод хяналт сул байна гэж үзлээ.*

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.*

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал* санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Acoulous4.0” програм хангамж ашиглажээ.

*Ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм хангам хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна.*

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын* бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 4 асуудал эрсдэл өндөр, 6 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 30 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 4 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь албан хаагчдын хурлаар материаллаг байдлын суурийг үр дүнгийн орлогоор тооцохоор тогтсонтой холбоотой юм.

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын* 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 368,1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 3,4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төсөвт байгууллагатай холбоотой юм.

## 2.6 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 10 эрсдэлтэй асуудалд 10 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 61 хувь буюу 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

| № | Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал | Тоо | Дүн  | Тайлбар |
|---|--|-----|------|---------|
| 1 | Зөвлөмж болгосон асуудал                             | 4   | 15,6 |         |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон                              | 2   | 1,0  |         |
| 3 | Албан шаардлага өгсөн                                |     |      |         |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн             | 0   | 0    |         |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн      | 0   | 0    |         |
|   | Дүн  | 6   | 16.6 |         |

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.7 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар нийт 24,1 сая төгрөгийн алдаа илрүүлсэн бөгөөд 7,5 сая төгрөгийн алдааг залруулан, 1,0 төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15,6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.



Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

### 2.7.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

2.9.1.1 Хурлын нарийн бичгийн даргад шийдвэргүйгээр зэрэг дэвийн нэмэгдэл олгосон нь МУЗГ-ын 2017 оны 04 сарын 14-ний өдрийн 29 тоот тогтоолын 1.1 дэх заалтын а/-д заасан "төрийн албан хаагчид зэрэг, дэв олгох буюу зэрэг, дэв ахиулах шийдвэрийг 2017 оны 5 дугаар сарын 1-нээс 2019 оны 12 дугаар сарын 31 хүртэл гаргахгүй байх" заалтыг зөрчсөн байна

2.9.1.2 Хууль эрхзүйн үндэслэлгүй, үр дүнгийн урамшуулал олгож төсвийг хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 2.7.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй

### 2.7.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

### 2.7.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

## 2.8 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал байхгүй

## 2.9 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 297,4 сая төгрөг баталсан бөгөөд, хөрөнгийн зардалд төсөв баталаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

| № | Үзүүлэлт                          | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь  | Зөрүү |
|---|-----------------------------------|------------|-----------|-------|-------|
| 1 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 297,4      | 297,2     | 99,9% | 0,2   |

|     |  |       |       |       |     |
|-----|--|-------|-------|-------|-----|
| 1.1 | Урсгал зардал                                | 297,4 | 297,2 | 99,9% | 0,2 |
| 1.2 | Хөрөнгийн зардал                             | 0     | 0     | 0.0%  | 0.0 |
| 1.3 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл   | 0     | 0     | 0.0%  | 0.0 |
| 2   | Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр                |       |       |       |     |
| 2.1 | Улсын төсвөөс санхүүжих                      | 297,4 | 296,8 | 99,8% | 0,6 |
| 2.2 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих |       |       |       |     |
| 2.3 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос |       | 0,2   |       |     |

Төсөвт зардлын гүйцэтгэл 99,9 хувь байгаа бөгөөд гараагүй байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогыг төлөвлөөгүй байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 71,1 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд зарцуулжээ.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

## 2.10 Шилэн дансны мэдээлэл

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.*

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 6 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 6 горим сорил хэрэгжүүлэв.

*Горим сорил хэрэгжүүлсний дүнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.*

## 2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг *Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал* 2017 оны 10 сарын 23 ны өдрийн 229 тоот албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягтлахад *Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.*

## 2.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид *Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын* 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

*Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын* 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь *Завхан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын* нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.**

|   |  |
|---|--|
| <b>3.1 Төсвийн зарцуулалт</b>   |  |
| <p><b><u>Илрүүлэлт</u></b></p> <p>-Төсвийг үрэлгэн зарцуулж бэлэг дурсгал, баяр ёслол, хоол, хүлээн авалт, хүндэтгэлд хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/ гэсэн заалтыг зөрчиж байна.</p> <p><b><u>Хариуцах ажилтан</u></b></p> <p>Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Балхярваа<br/>Нягтлан бодогч Ж. Бадамдорж</p>  | <p><b><u>Зөвлөмж</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах</li> <li>- МУЗГ-ын 2017 оны 04 сарын 14-ний өдрийн 29 тоот тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах</li> </ul>            |
| <p><b><u>Эрсдэл</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Төсвийг үрэлгэн зарцуулах</li> <li>- Хууль, журам зөрчигдөх</li> </ul>  | <p><b><u>Төсвийн захирагчийн хариу</u></b></p>   |
| <b>3.2 ГХУСАХ-ний зардал</b>  |  |
| <p><b><u>Илрүүлэлт</u></b></p> <p>-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн зарим ажлууд нь анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7/Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ гэсэн заалтыг зөрчиж байна.</p> <p><b><u>Хариуцах ажилтан</u></b></p> <p>Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Балхярваа<br/>Нягтлан бодогч Ж. Бадамдорж</p> | <p><b><u>Зөвлөмж</u></b></p> <p>-ГХУСАЗСЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад хөрөнгө гаргах,<br/>-Хөрөнгийг авч зарцуулсан байгууллагуудаас ажлын тайланг шалгаж, нягталж авах, холбогдох баримтуудыг бүрэн бүрдүүлэх</p> |
| <p><b><u>Эрсдэл</u></b></p> <p>-Төсөв зориулалтын бус зарцуулагдах</p>  | <p><b><u>Төсвийн захирагчийн хариу</u></b></p>   |

|  |   |
|--|---|
| <b>3.3 Авлага</b>  |   |
| <p><b><u>Илрүүлэлт</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Харицах эзэн нь тодорхой бус 2,4 сая төгрөгийн авлага тайланд тусгагдсан нь батламж мэдэгдлийн оршин байх гэсэн / Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх/ гэсэн стандартыг хангахгүй байна.</li> </ul> <p><b><u>Хариуцах ажилтан</u></b><br/>Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Балхярваа<br/>Нягтлан бодогч Ж. Бадамдорж</p>  | <p><b><u>Зөвлөмж</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авлагын насжилтийг тооцож, авлагыг барагдуулах ажил зохион байгуулах</li> </ul>   |
| <p><b><u>Эрсдэл</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх</li> </ul>  | <p><b><u>Төсвийн захирагчийн хариу</u></b></p>  |
| <b>3.4 ТЭЭВЭР ШАТАХУУНЫ ЗАРДАЛ</b>   |   |
| <p><b><u>Илрүүлэлт</u></b></p> <p>Жолоочийн тооцоо бодоогүй , шатахуун зарцуулалтын хэтрэлт, хэмнэлтийг нормоор тооцоогүй нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д / эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ гэсэн заалтыг зөрчиж байна.</p> <p><b><u>Хариуцах ажилтан</u></b><br/>Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Балхярваа<br/>Нягтлан бодогч Ж. Бадамдорж</p> | <p><b><u>Зөвлөмж</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Жолоочийн замын хуудасны тооцоог тухай бүр бодож байх</li> <li>- Автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт, хэмнэлийг тооцож байх</li> </ul> |
| <p><b><u>Эрсдэл</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсөв үрэлгэн зарцуулагдах</li> </ul>   | <p><b><u>Төсвийн захирагчийн хариу</u></b></p>  |

Тайлан бичсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор

Ч. Бямбасүрэн

Г.Хашцэцэг

Л.Уламбаяр